



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН
ГИШҮҮНИЙ ЗӨВЛӨМЖ**

2020 оны 11 дугаар сарын 25

№ 1/26

Улаанбаатар хот

**МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД БӨГӨӨД
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ДАРГА
Я.СОДБААТАР ТАНАА**

Монгол Улсад коронавируст халдварын дотоодын анхны тохиолдол бүртгэгдэж, Засгийн газрын шийдвэрээр бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбоотойгоор Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссоос Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсэг, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.6, 7.1.10, 18 дугаар зүйлийн 18.1.2-т тус тус заасны дагуу үүссэн нөхцөл байдалд бүрэн эрхийн хүрээнд шуурхай үнэлгээ, дүн шинжилгээ хийх, зарим байгууллагын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, иргэдийн ирүүлсэн гомдол, мэдээллийг шалгаж, шийдвэрлэх ажлыг зохион байгууллаа.

Тухайлбал, Комиссын гишүүд 2020 оны 11 дүгээр сарын 20, 23-ны өдрүүдэд Нийслэлийн Чингэлтэй дүүргийн 17, Баянзүрх дүүргийн 5, 22 дугаар хороодын нутаг дэвсгэр дэх засаг захиргааны болон нийтийн үйлчилгээний байгууллагууд, Нийслэлийн цагдаагийн удирдах газрын харьяа Түр хамгаалах байр, Хүүхэд, залуучууд, гэр бүл хөгжлийн газрын харьяа Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх түр хамгаалах байр, 107, 108 утас, Хан-Уул дүүргийн Хүүхэд хамгааллын байр, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, түүний харьяа Цагдан хорих 0461 дүгээр хаалттай ангийн үйл ажиллагаатай биечлэн танилцаж, холбогдох мэдээлэл, судалгааг гаргуулан авч дүн шинжилгээ хийлээ.

Мөн улсын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт хэсэгчилсэн байдлаар шилжүүлэх тухай Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 62 дугаар тогтоол, Бүх нийтийн бэлэн байдал зарлах тухай Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолыг тус тус хэрэгжүүлж эхэлснээс хойш Комисст иргэд, аж ахуйн нэгж, байгууллагаас нийт 539 гомдол, мэдээлэл ирүүлсний 51 нь цар тахалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр төрөөс хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой байна. Эдгээр гомдлын дагуу холбогдох ажиллагааг мөн явууллаа.

Дээрх үйл ажиллагааны хүрээнд цугларсан мэдээлэлд үндэслэж, бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэн цаг үед Монгол Улсын Үндсэн хууль, нэгдэн орсон олон улсын гэрээ, хууль тогтоомжоор баталгаажуулсан хүний эрх, эрх чөлөө зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх, хангах чиглэлээр холбогдох арга хэмжээг авах нь зүйтэй байх тул Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.3 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

000000047

1. 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдөр коронавируст халдварын дотоодын тохиолдол анх бүртгэгдсэний дараа халдвар авсан хүний болон ойрын хавьтлын хүмүүсийн овог нэр, регистрийн дугаар, зураг гэх мэт хувийн мэдээлэл олон нийтийн сүлжээгээр тараагдсан, тэднийг үзэн ядсан шинжтэй сэтгэгдэл түгээмэл илэрхийлэгдэж, халдвар авсан хүмүүс маршрутаа нуух, зөрүүтэй мэдээлэл өгсөн зэрэг нь бүх нийтийн эрүүл мэндэд аюултай нөхцөл байдал бий болгохоос гадна тандалт илрүүлгийн ажилд хүндрэл, бэрхшээл үүсгэж, халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй хүн халдлагад өртөх эрсдэлийг бий болгожээ. Иймд коронавируст халдвараар өвчилсөн, өвчилсөн байж болзошгүй хүний хувийн мэдээллийг хамгаалах, тэднийг ялгаварлан гадуурхах, гутаан доромжлохоос урьдчилан сэргийлэх, ийм үйл ажиллагааг хуульд заасан аргаар таслан зогсоох ажлыг үр дүнтэй зохион байгуулах;
2. Коронавируст халдвар илрүүлэх шинжилгээ авч байгаа цэгүүд, биеийн байдлын асуумж, байршил тэмдэглэх болон холбогдох албанаас өгч буй цаг үеийн мэдээллүүдийг харуулж буй E-barimt зэрэг аппликейшн, иргэний үнэмлэхийн QR кодыг ашиглахдаа хувь хүний халдашгүй чөлөөтэй байх эрхийг хангаж, хувийн өгөгдлийг зөвхөн коронавируст халдвартай тэмцэх үйл ажиллагаанд ашиглах, гуравдагч этгээдэд тараахгүй байх, иргэд, олон нийтэд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг алдагдуулахгүй байхад онцгой анхаарч ажиллах, хуулийн төсөл боловсруулах саналыг хууль санаачлах эрх бүхий албан тушаалтанд уламжлах;
3. Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, зарим аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор иргэдийн орлого тасарч, амьжиргааны түвшин буурч байгааг харгалзан Монгол Улсын Засгийн газар, Улсын онцгой комиссоос шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түр түдгэлзүүлж, иргэдийн арилжааны банк дахь данснаас суутгал хийхгүй байх асуудлыг судалж шийдвэрлэх;
4. Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасан журам, зааврыг батлан мөрдүүлэх үүрэгтэй байгууллагуудын нэрс тодорхой атал зарим төрийн байгууллага уг журам, зааврыг батлан мөрдүүлээгүй, эсхүл өөр субъект баталж мөрдүүлэх зэрэг тохиолдол гарсан байна. Иймд Коронавируст халдвар /Ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуульд заасан цар тахлын үед баримтлах зарчим, журам, зааврыг батлан мөрдүүлэх ажил хангалтгүй байгаад анхаарч хуулийн хэрэгжилтийг яаралтай хангах;
5. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас бүртгэлтэй өрхүүдэд хүнсний талоны мөнгийг шилжүүлэх арга хэмжээг авч байгаа ч цар тахлын үеийн нөхцөл байдлыг үндэслэж, бүртгэлд хамрагдаж амжаагүй, өдрийн орлогоор амьжиргаагаа залгуулдаг, хөл хорионы улмаас орлого нь тасарсан, баримт бичиггүйгээс нийгмийн халамж, хамгааллын үйлчилгээнд хамрагдаж чаддаггүй өрх, иргэдийг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран бүртгэлжүүлж, хүнсээр хангах, хүний амь нас, эрүүл мэндийг хамгаалахад зайлшгүй шаардлагатай халамж, үйлчилгээг хүргэх ажлыг зохион байгуулах;
6. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1-т төрийн байгууллагууд хүүхэд, гэр бүлийн асуудал эрхэлсэн байгууллагын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхдээ тус тусын хуулиар заасан чиг үүргийг хэрэгжүүлэх, хамтран ажиллахаар заасан бөгөөд 2019 онд Засгийн газрын 201 дүгээр тогтоолоор "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах,

тусламж дэмжлэг үзүүлэх журам"-ыг баталжээ. Гэвч Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолын хавсралтад дурдсан үйл ажиллагаанд нь хязгаарлалт тогтоохгүй төрийн байгууллага, хуулийн этгээдийн жагсаалтад дээрх байгууллагууд багтаагүй байна. Иймд зорилтот бүлгийн, эрсдэл өндөртэй хүүхэд, эмэгтэйчүүдэд тусламж дэмжлэг үзүүлэх, гэр бүлийн хүчирхийлэл болон хүүхэд хамгааллын үйлчилгээг тасралтгүй үзүүлэх, мэргэжлийн үйл ажиллагаагаа эрхлэх боломжоор хангах үүднээс Засгийн газрын дээрх тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулж, түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төв, хүүхэд, гэр бүлийн асуудал хариуцсан орон нутгийн төрийн захиргаа, асрамж, халамжийн байгууллагын ажилтнуудыг ажиллах нөхцөл боломж, хамгаалах хэрэгслээр хангах;

7. Улсын онцгой комиссоос өгч буй шуурхай мэдээллээр гэр бүлийн болон хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, эрсдэл учирсан тохиолдолд хаана хандах болон түр хамгаалах байр, нэг цэгийн үйлчилгээний төвүүд, гэр бүлийн хүчирхийллийн талаарх дуудлага мэдээлэл зөвлөгөө өгөх 107 утас, хүүхдийн тусламжийн 108 утасны талаарх мэдээллийг тогтмол, хүртээмжтэй хүргэх, хөл хорионы улмаас гэр бүлийн хүчирхийлэл далд хэлбэрт шилжсэн байж болзошгүй эрсдэлийг тооцож, хариу арга хэмжээ шуурхай төлөвлөн ажиллах, түр хамгаалах байрны нөөцийг нэмэгдүүлэх;
8. Тусгаарлах байруудын удирдлага, зохион байгуулалт, тусгаарлагдсан хүмүүсийн санал хүсэлтийг шийдвэрлэх ажиллагаа тодорхой биш байна. Зарим тохиолдолд тусгаарлалтад авсан иргэдийн шинжилгээний хариу, эрүүл мэндийн байдлын талаар өөрт нь мэдэгдэлгүйгээр хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлсэн нь хүнлэг ёсны зарчимд нийцэхгүйг анхаарч тусгаарлагдсан иргэдийн мэдэх эрхийг хангаж, хүний эрхэм чанарыг хүндэтгэн харилцах чиглэлийг холбогдох алба хаагчдад өгөх;
9. Гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан тусгай үүргийн нислэгүүдийг цуцалсанаас болж Франкфурт-Улаанбаатар болон бусад чиглэлийн нислэгээр эх орондоо эргэн ирэхээр төлөвлөж байсан иргэд хүнд нөхцөлд байдалд орсон талаар удаа дараа гомдлууд ирж байна. Эдгээр иргэдийг нэн даруй тусгай үүргийн нислэгээр татан авах ажлыг зохион байгуулах, мөн гадаадад гацсан, орон байр, хоол хүнсний гачигдалд орсон иргэдэд дэмжлэг, туслалцаа үзүүлэх асуудлыг яаралтай шийдвэрлэх;
10. Буяны ажил, гэр бүл, эрүүл мэндийн зэрэг хүндэтгэн үзэх шалтгаанаар Улаанбаатарт болон орон нутагт ирээд хөл хорионд орсон, нутаг буцах зайлшгүй шалтгаантай иргэдийг нэн түрүүнд оношлогоонд оруулж, орон нутагт нь буцаах ажлыг зохион байгуулах, орон нутагт төлбөртэй оношлогоо, тусгаарлалт хийх зохицуулалтыг дэмжихгүй байх;
11. Анх удаа гэмт хэрэг үйлдсэн болон насанд хүрээгүй хүнд цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээ авахгүй байх, хорих анги, цагдан хорих, баривчлах байранд хувийн ариун цэвэр сахихад хүрэлцэхүйц хэрэглэгдэхүүнээр хоригдогсод болон алба хаагчдыг хангах;
12. Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 178 дугаар тогтоолын хавсралт, Нийслэлийн Засаг даргын 2020 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн А/1242 дугаар захирамжид заасан хязгаарлалтад хамрагдахгүй байгууллага, хуулийн этгээдэд шүүх, прокурорын байгууллагыг оруулсан боловч хэрэг маргааны нэг тал болох өмгөөлөгчдийн үйл ажиллагааг орхигдуулсан нь Монгол


Улсын Үндсэн хуульд баталгаажуулсан иргэний хууль зүйн туслалцаа авах эрх зөрчигдөх эрсдэл бий болгож байна. Иймд өмгөөлөгчдөд шүүх, прокурор, АТГ, ТЕГ, цагдаагийн байгууллагаас цахим болон цаасан хэлбэрээр өгсөн тодорхойлолтыг үндэслэн хөдөлгөөнд оролцож, мэргэжлийн үйл ажиллагаагаа явуулах боломжийг бүрдүүлэх;

13. Орон нутгийн Онцгой комисс, Засаг даргын шийдвэрээр коронавируст халдварын цар тахлын үед ажиллаж байгаа эмч, эмнэлгийн ажилтнууд, цагдаа, онцгой, мэргэжлийн хяналтын байгууллагаас бусад төрийн алба хаагчид, тухайлбал батлан хамгаалах, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын алба хаагчдад олгох урамшууллыг шийдвэрлэх;

14. Онцгой байдлын ерөнхий газрын 1800-1105 дугаарын шуурхай утас тогтмол ажилладаггүй, дуудлага хүлээж авдаггүй, тодорхой мэдээлэл өгдөггүй гэх гомдол иргэдээс удаа дараа ирж байгаа тул дээрх утасны байнгын ажиллагааг хангах, Улсын онцгой комиссын гаргасан шийдвэртэй холбоотой тодруулга, мэдээлэл, зөвлөгөөг иргэдэд шуурхай, ойлгомжтой, хүргэхэд анхаарах;

Энэхүү Зөвлөмжийн мөрөөр Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1, 28.2 дахь хэсэгт заасны дагуу арга хэмжээ авч 7 хоногийн дотор хариу ирүүлнэ үү.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ, ГИШҮҮН



Ж.ХУНАН